



**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

**Гүйцэтгэх захиралд эрх
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ :

1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй тохиолдолд “Шивээ Овоо” ХК-ийн гүйцэтгэх захирал /О.Отгонбаатар/-д 80.000.000 сая төгрөг хүртэлх аливаа бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хэлцлийг бие дааж хийх эрхийг олгосугай.

2. Компанийн нээлттэй тендерийн Үнэлгээний хороонд толгой компанийн мэргэжилтнийг тухай бүр толгой компанитай тохиролцож оруулахыг гүйцэтгэх захирал /О.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг гарсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 01 сарын 29-ны өдрийн 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ТҮМЭНЦОГТ